БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА ... ТӨМӨРБААТАР

2024 оны 07 дугаар сарын ... ны өдөр

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 22 ДУГААР ХОРООНД ХИЙГДЭХ ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

| | | |
|---|---|---|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | • Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>• Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 16/01 дүгээр тогтоол |
| 2. | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороонд хийгдэх гэрэлтүүлгийн тоо ширхэгийг хавсаргав.<br>-Хилчин 30, 70, 71 дүгээр гудамж<br>**Нийт шонгийн тоо 59 ширхэг** |
| 3 | Одоогийн байдал | Гэрэлтүүлэг хийгдээгүй шинээр төлөвлөх. |
| 4 | Зураг, төсөв боловсруулахад ашиглах материал | Хууль тогтоомж:<br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Эрчим хүчний тухай хууль<br>Норм, норматив, стандартууд:<br>- Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД43.101.03<br>- Байгалийн зохиомол гэрэлтүүлэг БНбД23-02-08<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>- Барилга байгууламжийн зураг төсөл, зохиох галын аюулгүйн норм БНбД21.02.02<br>- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД30-10-04)<br>- Хот, тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх БД 30-102-11<br>- Бусад холбогдох норм, дүрэм, заавар |
| 5 | Төсөл гүйцэтгэх хугацаа | Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 6 | Төслийн захиалагч | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 7 | Төсөл боловсруулах байгууллага | Барилга хот байгуулалтын яамны сайдын тушаалаар батлагдсан " Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 03.2.1, 03.2.02, 03.2.3, 03.2.4 хот тосгоны суурь судалгаа боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой. |

| | | |
|---|---|---|
| 8 | Төсөл боловсруулах үе шат | Хоёр үе шаттай боловсруулна.<br>- Судалгаа техникийн төсөл<br>- Тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах |
| 9 | Архитектур орон зайн төлөвлөлтөнд тавигдах шаардлага | -Хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэх норм дүрмийн дагуу онцлог хэв маяг шийдлийг тусгах өгөх. |
| 10 | Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага | - Техникийн нөхцөлд тавигдсан шаардлагын дагуу, олон улсын чанарын стандарт хангасан тоног, төхөөрөмж, кабель, шугам, материалыг сонгох.<br>- Цахилгаан хангамжийн шугамд одоо холбогдож байгаа хэрэглэгч ба хэтийн төлөвлөлтөөр хэрэглэгчдийг холбох боломжийг бүрдүүлэх<br>- **Цахилгаан хангамж:** Төвлөрсөн цахилгаан хангамжийн шугам сүлжээнээс хангагдана.<br>- Удирдлагын шит: Шинээр төлөвлөгдөх гэрэлтүүлгүүдийн удирдлагын шит нь Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төвийн хяналтад байдаг гэрэлтүүлгийн нэгдсэн удирдлагын Тулга системд холбогдоно.<br>- UCS 1901B:2020 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг хангуулах.<br>- UCS1902A:2022 Гэрэлтүүлэх төхөөрөмжийг байрлуулах, суурилуулах, технологийн удирдамж |
| 11 | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон түүнтэй ижил, цалинг дундаж зэргээр тооцдог, зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно. |
| 12 | Зураг төслийн санхүүжилт | - Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө |
| 13 | Төслийн иж бүрдэл | Баримт бичгийн иж бүрдэл:<br>- Одоогийн байдлаар судалгаа<br>- Тайлбар бичиг<br>- Тайлбар бичиг, техник эдийн засгийн үзүүлэлт<br>- Хөрөнгө оруулалтын тооцоо<br>- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө<br>График, зураглалын иж бүрдэл<br>- Нүүр хуудас / батлагдах/<br>- Байршлын схем M1:2000<br>- Одоогийн байдал M1:1000<br>- Дэвсгэр зураг M1:5000-M1:2000<br>- Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтыг шинэчлэх төлөвлөх M1:200-500<br>- Өндөржилт M1:200-500<br>- Зай хэмжээ M1:200-500<br>- Картограмм M1:200-500<br>- Цахилгаан хангамж M1:100-200<br>Зураг төсөлд тавигдах шаардлага:<br>- Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх<br>- Зураг төслийн хот байгуулалтын мэдээллийн санд |

| | | |
|---|---|---|
| | | хүлээж авахад тавигдах шаардлага .<br>А. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх<br>Б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84 UTM буюу солбилцлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх.<br>Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна.<br>-Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба<br>-Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар<br>-Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК<br>-Холбогдох бусад байгууллага |
| 14 | Онцгой нөхцөл | - Тус ажил нь зураг төсөвгүй бөгөөд шинээр зураг, төсөв, боловсруулан магадлалаар баталгаажуулна. Гэрэлтүүлгийн ажлыг батлагдсан төсөвт өртөгт багтах хэмжээгээр ажлын зураг, төсвийг боовсруулсны дараа барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.<br>- Ажлын зурагт бусад инженерийн шугам, сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөх.<br>- Цахилгааны шугам, сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх.<br>- Төлөвлөж буй цахилгаан хангамжийн шугам сүлжээнд одоо холбогдсон болон төлөвлөлтөөр холбогдох хэрэглэгчдийн ачааллыг тусгасан байх.<br>- Ойр орчмын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч компаниудын цахилгаан хангамжийн трасстай уялдуулан төлөвлөсөн байх.<br>- Автозамын нэвтрэх хэсэгт төлөвлөсөн инженерийн шугам, сүлжээний хонгилын системтэй уялдуулах.<br>- Зургийн ажлыг хийхдээ дүүрэг, ашиглагч байгууллагатай газар дээр нь явж судлах.<br>- Шугам сүлжээний хамгаалалтыг зайг баримтлах.<br>- Эрчим хүчний хэмнэлттэй лед болон түүнтэй дүйцэхүйц шар тусгалтай гэрэлтүүлэгч сонгоно.<br>- Инженерийн хангамжийн асуудлыг тооцоо, судалгааны үндсэн дээр хийх.<br>- Инженерийн шугам, сүлжээ нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд булгалт, зөөж шилжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг зураг төсөв боловсруулах.<br>- Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төсвийг боловсруулах.<br>- Гэрэлтүүлгийн зураг төсвийг гүйцэтгэхдээ доорх техникийн үзүүлэлтийг харгалзан үзнэ.<br><br>**Гадна гэрэлтүүлгийн техникийн үзүүлэлт** |

| № | Материалын нэр | Нийтийн эзэмшлийн төв замууд | | Орон сууц | Гэр хороолол |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гэрэлтүүлг | 180Вт | 120Вт | 90Вт | 70ВТ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ийн толгой | LED | LED | LED | LED /шар/ |
| | | 2 | Шонгийн өндөр | 12м | 9м | 9м | 8м |
| | | 3 | Кранштейны урт /тахир толгой/ | 2м | 2м | 1,5м | 1м |
| | | 4 | Шонгийн хэлбэр | Конус ба фланцтай залгаа шон | | | |
| | | 5 | Шонгийн диаметр | Ф50x133x219 | | Ф50x100x159 | |
| | | 6 | Зузаан | 3,5 мм-ээс дээш | | | |
| | | 7 | Хоорондын зай | 35-40м | | 30-35м | 25-30м |
| | | 8 | Суурь | 150x80x60 | | 120x60x40 | Чагтан холбоос бүхий бэхэлгээтэй |
| | | 9 | Тэжээлийн кабель | 3x50+1x35 АВВБ | | 3x35+1x25 АВВБ | 3x25+1x16 АВВБ |
| | | 10 | Группын кабель | 3x50+1x25 АВВБ | | 3x25+1x16 АВВБ | СИП-2А 3x16+1x25 |

ХЯНАСАН:
ТОХИЖИЛТ НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.НЯМХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:
ТОХИЖИЛТ НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ, КАМЕРЖУУЛАЛТ, РЕКЛАМНЫ БАЙГУУЛАМЖ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭДЭНСҮРЭН